



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/764

Арвайхээр

Ажлын хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Зорилтот жил болгон зарлах тухай” 2019 оны 12/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өвөрхангайд үйлдвэрлэв” жилийн ажлыг аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Ажлын хорооны дарга: Ц.Ганболд -аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга: Н.Дулам -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Г.Баясгалан -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
С.Дуламсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга
Т.Ариунболд -аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
С.Ундрах -аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
Н.Гуамарал -аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Ц.Ариунаа -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын албаны дарга
Б.Ууганбаяр -Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Өвөрхангай аймаг дахь салбарын дарга
Д.Цэвэлсүрэн -Өвөрхангай аймгийн үе үеийн худалдаа эрхлэгчдийн холбоо төрийн бус байгууллагын тэргүүн (зөвшилцсөнөөр)
О.Гансүх -аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн (зөвшилцсөнөөр)

2. “Өвөрхангайд үйлдвэрлэв” жилийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хороо (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

3. “Өвөрхангайд үйлдвэрлэв” жил болгон зарласантай холбогдуулан орон нутагтаа ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэн, үр дүн тооцож ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101451